



САНТ СУМЫН МОНГОЛ  
АРДЫН НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022-07-30 № ССА-2022/04-НА-12  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Сант сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Сант сумын Монгол Ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

## Дүгнэлт

Сант сумын Монгол Ардын намын хорооны Сант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сант сумын Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /...3.... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сант сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМАГ САНТ СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН 2020 ОНЫ  
ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**2020 он**



**СЭЛЭНГЭ АЙМАГ САНТ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН 2020 ОНЫ ОРОН  
НУТГИЙН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**


- 1.1. Хүүхэд багачуудыг сумынхаа түүх, соёл, уламжлалыг мэддэг, хөдөлмөрт дуртай, нутаг орноороо бахархах үзэл хүмүүжилтэй, амьдралын зөв дадал хэвшилтэй, боловсролтой иргэн болгон төлөвшүүлэх “Бид Сант сумын ирээдүй” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.2. Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл хүсэлтийг шуурхай шийдвэрлэж тушаал шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр иргэдэд түгээж иргэдийн оролцоог нэмэгдүүлэх цахимаар мэдээлэл солилцох боломж бүрдүүлнэ.
- 1.3. Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу байдал үүсгэхгүй байх, явцуу сонирхол, намын харьяалаар иргэдэд ялгавартай хандахгүй байх, төрийн үйлчилгээг иргэн бүрд тэгш хүртээнэ.
- 1.4. Сумандаа “Залуучууд хөгжлийн төв” байгуулах асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 1.5. Гэр бүл, хүүхэд оюутан залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг сайжруулна.
- 1.6. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээт иргэдийг хамгаалах, мэдээлэл зөвлөгөө авах боломжийг бүрдүүлнэ.

**ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ**

- 2.1. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой айл өрхийг мал аж ахуй, гахай, шувуу, зөгий аж ахуй эрхлэхийг дэмжинэ.
- 2.2. Мал эмнэлгийн үйл ажиллагаанд төрөөс тавих хяналтыг сайжруулан урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанаржуулж “Эрүүл малтай” сум болгоно.
- 2.3. Мал аж ахуйн түүхий эд бүтээгдэхүүнийг чанар стандартын дагуу бэлтгэн нийлүүлэх ажлыг зохион байгуулж малчдыг бүрэн хамруулна.

**ГУРАВ. ДЭД БҮТЭЦ**

- 3.1. Сумын цэвэр усны магистрал шугамыг сэргээн засварлах ажлыг үргэлжлүүлнэ.
- 3.2. Ундны усны түгээх цэгүүдийг тохижуулж, ухаалаг тоолууртай болгоно.
- 3.3. Сумын хэрэглээний усны хатуулгыг хэмжих, зөөлрүүлэх төхөөрөмжийг суурилуулж, баталгаат ундны усаар хангана.
- 3.4. Ивэн багийн нутагт байрлах Дарцаг, Түргэн, Шандын давааны авто хөсөг зорчих замыг засварлана.
- 3.5. Сумын төвийн цэвэрлэх байгууламжийг шинээр бий болгох тооцоо судалгааг хийж, дээд шатны байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 3.6. Үүрэн холбооны операторуудтай хамтарч Хушаат багийн алслагдсан сууринд сүлжээ тавих ажлыг дэмжиж ажиллана.





## ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙ

4.1. Суманд Органик тариаланг хөгжүүлэх. Иргэдийн оролцоотой бүлэг хоршооны үйл ажиллагааг тогтворжуулна.

4.2. Сумын төмс хүнсний ногоо тариалагчдын талбайн хөрсний үржил шимийг сайжруулах, таримал ургамлыг эрчимжүүлэх, ургацыг нэмэгдүүлэх зорилгоор “ЭКО”<sup>3998</sup> бордоог үйлдвэрлэх өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.



4.3. Сумын жимс жимсгэнийн тариалалтыг өргөжүүлж иргэдийн оролцоотойгоор жимс жимсгэнэ үржүүлэх, бүлэг хоршоодын санал санаачилгыг бүх талаар дэмжинэ.

4.4. Төмс хүнсний ногооны стандартын шаардлага хангасан үр нийлүүлэх арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.

4.5. Ивэн голын даланг сэргээн засварлах ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх асуудлын холбогдох тооцоо судалгааг боловсруулан дээд шатны байгууллагад уламжлуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллана.

4.6. Будлан, Номунхан хорооллуудын айл өрхүүдийг хашаандаа сайхан амьдрах орчин бүрдүүлэхэд цэвэр усны шугамтай холбох ажлыг үргэлжлүүлнэ.

4.7. Сумын төвийн өрх бүр жимс жимсгэнийн мод бут тарих, хүрээлэн буй орчноо ногоон төгөл болгох, хашаандаа сайхан амьдрах орчин бүрдүүлэх ажлыг дэмжинэ.

4.8. Иргэдэд төмс хүнсний ногоо тариалах зориулалтаар эзэмших газрыг хуулийн тогтоомжийн дагуу олгоно.

4.9. Суманд мал амьтны гаралтай арьс шир боловсруулах талаарх санал санаачилгыг дэмжиж ажиллана.

4.10. Суманд малын мах сүү боловсруулах үйлдвэрлэх иргэдийн санал санаачилгыг дэмжинэ.

4.11. Бэлчээрийг нөхөн сэргээх арга хэмжээг малчдын бүлэг хоршоотой хамтарч авч хэрэгжүүлнэ.

4.12. Сүү, махны чиглэлийн Герпорд үүлдрийн үхрийн эрчимжсэн аж ахуйг эрхлэхийг дэмжиж ажиллана.

4.13. Иргэдийн хүлэмж, зоорины аж ахуйн эрхлэлтийг нэмэгдүүлэх, хүнсний ногоог зах зээлд борлуулах боломжийг бүрдүүлнэ.

## ТАВ. БОЛОВСРОЛ СОЁЛ УРЛАГ ШИНЭЧЛЭЛ

5.1. ЕБС-ийн өндөр хурдны интернэт, мэдээлэл зүй кабинетыг иж бүрэн тохижуулах багш сурагчдын ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

5.2. Сумын ном сангийн номын баяжилтыг жил бүр нэмэгдүүлж, хүүхэд залуучууд иргэдийн цахим номын уншлага ашиглах орчныг бүрдүүлнэ.

5.3. Сумын орон нутгийн сурталчлах танхимыг зохих стандартын дагуу тохижуулна.


5.4. Уламжлалт Монгол ахуй ёс зан заншил түүх соёлын уламжлалыг дээдэлсэн монгол хэл бичгийн өргөөтэй болно.

5.5. ЕБС-ийн сурагчдыг хөдөлмөр, амралтын зусланг сэргээн байгуулах ажлыг дэмжиж ажиллана.

5.6 Суралцагчдын хамран сургалтыг нэмэгдүүлж сургалтын чанар, үр, өгөөжийг дээшлүүлэхэд анхаарч ажиллана.

5.7 Баруун бүсийн хэмжээнд сургалтын материаллаг бааз, сургалтын амжилт чанараар тэргүүлсэн “Хүслийн ЭКО” сургууль болгон хөгжүүлнэ.

5.8 Бүх насны иргэдэд зориулсан онлайн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



### **ЗУРГАА. АХМАД НАСТАН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ЭМЭГТЭЙЧҮҮД**

6.1 Ахмад настнуудыг жижиг дунд үйлдвэрлэл эрхлэхийг дэмжих, тэдний мэдлэг туршлагыг залуу үед өвлүүлэхэд хамтран ажиллана.

6.2 Ахмад настнуудын чөлөөт цагийг ая тухтай орчинд үр дүнтэй өнгөрүүлэх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана.

6.3 “Залуучууд хөгжлийн төв” байгуулах ажлын тооцоо судалгааг хийж, дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

### **ДОЛОО. ЭРҮҮЛ МЭНД**

7.1. Эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажиллана.

7.2. Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмад настан, зорилтот бүлгийн иргэдийн дунд эрүүл аж төрөх дадал хэвшлийг бий болгох үүднээс зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, идэвхтэй эрүүл амьдралын хэвшлийг бий болгоход анхаарч ажиллана.

7.3. Сумын эрүүл мэндийн төвийн ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч ажиллана.

### **НАЙМ. БАЙГАЛЬ ОРЧИН НОГООН ХӨГЖИЛ**

8.1 Байгаль орчин хамгаалах үйл ажиллагаанд ойн нөхөрлөл, малчдын бүлэг, иргэдийн оролцоог нэмэгдүүлж ажиллана.

8.2 Баавгайт, Хөндлөнгийн Рашаан зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудад аялал жуулчлал амралт сувилал байгуулах иргэд, нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.

8.3 Ахуйн хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож шинэ түвшинд гаргана.

8.4 Сурагчдын байгалийн ухааны хичээлийн туршилтын талбай байгуулж, амьдрах ухааны дадал хэвшлийг бүрдүүлнэ.